

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангиллын код

Тохирлын үнэлгээ - Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтыг гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага - 13-р хэсэг: Нийцлийн менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтад тавих чадавхын шаардлага	MNS ISO/IEC TS 17021-13:2024
Conformity assessment — Requirements for bodies providing audit and certification of management systems — Part 13: Competence requirements for auditing and certification of compliance management systems	ISO/IEC TS 17021-13:2021

Стандарт, хэмжил зүйн газрын даргын оны дугаар сарын ... -ны өдрийн дугаар тушаалаар батлав.

Энэ стандартыг оны дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь нийцлийн менежментийн тогтолцоо (НМТ)-ны аудит болон баталгаажуулалтын үйл явцад оролцох ажилтны чадавхад тавих нэмэлт шаардлагыг тогтоох бөгөөд ISO/IEC 17021-1 стандартын хавсралт болно.

2 Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг бүхлээр нь эсхүл хэсэгчлэн эш татсан бөгөөд энэхүү стандартыг хэрэглэхэд салшгүй хэсэг нь байна. Огноо заасан эшлэлийн хувьд зөвхөн тухайн хэвлэлийг хэрэглэнэ. Огноо заагаагүй эшлэлийн хувьд эш татсан баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэл (аливаа нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

ISO/IEC 17021-1:2015, Тохирлын үнэлгээ — Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтыг гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага. 1-р хэсэг: Шаардлага

ISO 37301:2021, Нийцлийн менежментийн тогтолцоо – Шаардлага ба хэрэглэх зааварчилгаа

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү баримт бичигт ISO 37301 болон ISO/ICE 17021-1 стандартад заасан нэр томъёог хэрэглэнэ.

ОУСБ (ISO) ба ОУЦТК (IEC) нь стандартчилалд ашиглах нэр томъёоны өгөгдлийн санг эрхлэн хариуцах ба дараах хаягаар дамжуулан хүргэж байна:

- ОУСБ (ISO)-ын цахим хайлтын талбар: www.iso.org/obp
- ОУЦТК (IEC)-ын цахим лавлах: www.electropedia.org

4 Ерөнхий чадавхын шаардлага

Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021-1 стандартын А.1 хүснэгтэд заасны дагуу баталгаажуулалтын чиг үүрэг тус бүрийн чадавхын шаардлагыг тодорхойлно. Баталгаажуулалтын байгууллага нь эдгээр чадавхын шаардлагыг тодорхойлохдоо ISO/IEC 17021-1 стандарт, холбогдох 5, 6-р бүлэгт заасан шаардлагыг авч үзнэ.

1-Р ТАЙЛБАР: А хавсралтад тодорхой баталгаажуулалтын чиг үүрэгт оролцох ажилтанд тавих чадамжийн шаардлагыг тусгасан болно.

2-Р ТАЙЛБАР: Аудитын зарчмын талаарх мэдээллийг ISO 19011 стандартад тусгасан болно.

5 Нийцлийн менежментийн тогтолцоо (Нийцлийн МТ)-ны аудитын багт тавих чадавхын шаардлага

5.1 Ерөнхий зүйл

5.1.1 Нийцлийн МТ-ны аудитын багийн бүх гишүүд нь ISO/IEC 17021-1-д заасан ерөнхий чадавх, ISO 37301 стандартын шаардлага болон тэдгээр шаардлагуудын уялдаа холбооны талаарх ойлголттой, 5.2-өөс 5.5-д заасан Нийцлийн МТ-ны мэдлэг, чадавхын түвшинтэй байна.

5.1.2 5.2-өөс 5.5-д заасан чадавхын шаардлагууд нь аудит хийгдэх Нийцлийн МТ-ны хамрах хүрээнд хамаарна.

ТАЙЛБАР: Аудитын багийн гишүүн бүр нэг ижил чадавхтай байх шаардлагагүй боловч аудитын багийн хамтын чадавх нь аудитын зорилгыг хэрэгжүүлэхэд хангалттай байна.

5.2 Байгууллагын төлөв байдал

5.2.1 Аудитын баг нь байгууллагын үйл ажиллагааны төлөв байдлын талаар мэдлэгтэй байна. Аудитын баг нь байгууллагын бизнесийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл болон заавал дагаж мөрдөх буюу нийцлийн үүрэгтэй холбоотой тухайн байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, үйл явцыг таньж, ойлгох чадвартай байна.

5.2.2 Аудитын баг нь байгууллагын холбогдох нийцлийн үүрэг болон эрсдэлийг тодорхойлж, ойлголттой болохын тулд судалгаа хийх шаардлагатай мэдлэг, ур чадвартай байна.

5.3 Хууль тогтоомж, зохицуулалт болон бусад шаардлага

5.3.1 Аудитын баг нь олон төрлийн хууль тогтоомж, зохицуулалт болон эрх зүйн тогтолцооны талаарх мэдлэг ба ойлголттой байна. Аудитын баг нь олон төрлийн эрх

зүйн бичвэр, тэдгээрийн байгууллагын нийцлийн үүрэгт хамаарах байдлыг таньж, ойлгох мэдлэг, ур чадвартай байна.

5.3.2 Аудитын баг нь байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчны талаар мэдлэгтэй байх бөгөөд аудит хийгдэх Нийцлийн МТ-ны хамрах хүрээнд холбогдох нийцлийн үүрэг болон нийцлийн эрсдэлийг таньж, ойлгох чадвартай байна.

5.3.3 Аудитын баг нь аудит хийгдэх Нийцлийн МТ-ны хамрах хүрээнд бусад шаардлага(ууд)-аас үүсэх нийцлийн үүрэг, эрсдэлийн хамаарлыг таньж, ойлгох чадвартай байхын тулд холбогдох бусад шаардлагын талаар мэдлэгтэй байна.

ТАЙЛБАР: Холбогдох бусад шаардлагуудад, тухайлбал, удирдлагын захирамж бичиг буюу тушаал, лицензийн гэрээ, сайн дураар дагаж мөрдөх дүрэм, байгууллагын болон салбарын стандарт, гэрээний харилцаа, үйл ажиллагааны дүрэм, нийгмийн бүлэг эсхүл төрийн бус байгууллагатай байгуулсан гэрээ зэргийг хамруулж болно.

5.4 Нийцлийн эрсдэлийн үнэлгээ ба хяналт

5.4.1 Аудитын баг нь ISO 37301:2021 стандартын 4.6-д заасан нийцлийн эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийдэг талаар мэдлэгтэй байна.

5.4.2 Аудитын баг нь нийцлийн эрсдэлийг үнэлэх, түүнийг арилгахад ашигладаг аргачлал(ууд)-ын талаар мэдлэг, ойлголттой байна.

5.4.3 Аудитын баг нь нийцлийн хяналтыг үнэлэх мэдлэг, ойлголттой байна.

5.5 Нийцлийн менежментийн тогтолцоо (НМТ)

5.5.1 Аудитын баг нь ISO 37301 стандартын дагуу Нийцлийн МТ-г хэрхэн бий болгож, хэрэгжүүлэх талаар мэдлэг, ойлголттой байна.

5.5.2 Аудитын баг нь хамгийн багадаа дараах зүйлсийн талаар тодорхой Нийцлийн МТ-ны мэдлэгтэй байна. Үүнд:

- a) нийцлийн соёлын хүчин зүйлс болон үзүүлэлтүүд;
- b) нийцлийн МТ-г үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах манлайлал;
- c) нийцлийн чиг үүрэг бүхий нэгжийн үүрэг оролцоо, хариуцлага;
- d) нийцлийн сургалт;
- e) нийцлийн хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийх, үнэлэх, тайлагнах үйл явц;
- f) анхаарах шаардлагатай асуудлыг мэдээлэх тогтолцоо, түүнийг шийдвэрлэх үйл явц;
- g) үл нийцлийн тохиолдлыг хянан-шалгах үйл явц.

6 Бусад ажилтнуудад тавих чадавхын шаардлага

6.1 Ерөнхий зүйл

Шаардлагатай аудитын багийн чадавхыг тодорхойлох зорилгоор өргөдөлд дүн шинжилгээ хийх, аудитын багийн гишүүдийг сонгох болон аудитын хугацааг тогтоох мөн аудитын тайлан дүн шинжилгээ хийх, баталгаажуулалтын шийдвэр гаргах ажилтнуудыг бусад ажилтан гэнэ.

Бусад ажилтнууд нь ISO/IEC 17021-1 стандартад заасан ерөнхий чадавхтай байх ба ISO 37301 стандартын шаардлага болон тэдгээр шаардлагуудын уялдаа холбооны талаарх ойлголт, 6.2-т заасан Нийцлийн МТ-ны мэдлэгийн шаардлагыг хангасан байна.

6.2 Байгууллагын төлөв байдал

Бусад ажилтнууд нь байгууллагын үйл ажиллагааны төлөв байдлын талаар мэдлэгтэй байна. Бусад ажилтнууд нь аудит хийх Нийцлийн МТ-ны хамрах хүрээнд байгууллагын бизнесийн үйл ажиллагааны нийцлийн үүрэгтэй холбоотой тухайн байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, үйл явцыг таньж, ойлгох чадвартай байна.

А хавсралт
(мэдээллийн)

НМТ-ны аудит болон баталгаажуулалтын талаарх мэдлэг

А.1 хүснэгт нь АЭМТ-ны аудит ба баталгаажуулалтанд шаардлагатай мэдлэгийг нэгтгэсэн байдлаар харуулсан болно. Энэ нь зөвхөн баталгаажуулалтын тусгай чиг үүргийн мэдлэгийн хүрээг тодорхойлно. 4, 5 ба 6-р бүлэг болон А.1 хүснэгтэд заасан ажиллагаа тус бүрд тавих чадавхын шаардлага нь тусгай шаардлагын эш таталтыг заана.

А.1 хүснэгт – НМТ-ны аудит ба баталгаажуулалтын талаарх мэдлэг

Мэдлэг	Баталгаажуулалтын чиг үүрэг		
	Аудитын багт шаардагдах чадавхыг тодорхойлох зорилгоор өргөдөлд дүн шинжилгээ хийх, аудитын багийн гишүүдийг сонгох болон аудитын хугацааг тогтоох	Аудитын тайланд дүн шинжилгээ хийх болон баталгаажуулалтын шийдвэр гаргах	Аудитын баг
Ерөнхий зүйл	6.1	6.1	5.1
Байгууллагын төлөв байдал	6.2	6.2	5.2
Хууль тогтоомж, зохицуулалт болон бусад шаардлага	-	-	5.3
Нийцлийн эрсдэлийн үнэлгээ ба хяналт	-	-	5.4
Нийцлийн менежментийн тогтолцоо (НМТ)	-	-	5.5

Ном зүй

[1] ISO 19011, Менежментийн тогтолцооны аудитын арга зүйн заавар

[2] ISO 31000, Эрсдэлийн менежмент – Арга зүйн заавар

[3] Менежментийн тогтолцооны стандартуудыг нэгтгэн хэрэглэх нь, ОУСБ-ын гарын авлага

СТАНДАРТЫН ТӨСӨЛ